



Монгол Улс: Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах хөтөлбөр

Төслийн нэр	Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах хөтөлбөр
Төслийн дугаар	51199-001
Төсөл хэрэгжих улс	Монгол Улс
Төслийн статус	Батлагдсан
Төслийн төрөл / Тусламжийн хэлбэр	Зээл
Санхүүжилтийн эх үүсвэр / Мөнгөн дүн	Зээл 3648-МОН: Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах хөтөлбөр Ердийн хөрөнгийн эх 130 сая ам.доллар үүсвэр
Холбогдох стратегийн зорилт	Байгаль орчинд ээлтэй тогтвортой өсөлт Эдийн засгийн хүртээмжтэй өсөлт
Өөрчлөлтийн чиглэлүүд	Засаглал ба чадавхийн хөгжил
Салбар / Дэд салбар	Эрчим хүч – Эрчим хүчний салбарын хөгжил ба байгууллагын өөрчлөлт шинэчлэл Эрүүл мэнд - Эрүүл мэндийн салбарын хөгжил ба өөрчлөлт шинэчлэл Төрийн салбарын удирдлага – Төрийн удирдлага Тээвэр – Тээврийн салбарын бодлого, байгууллагын хөгжил Ус ба хотын бусад дэд бүтэц, үйлчилгээ – Хот байгуулалтын бодлого, байгууллагын ба чадавхийн хөгжил
Жендэрийн тэгш эрх ба жендэрийн тэгш эрхийн үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь	Жендэрийн зарим бүрэлдэхүүн хэсэгтэй төсөл
Төслийн тодорхойлолт	Улаанбаатар хотод хурцаар тавигдаж буй агаарын бохирдлын асуудлыг шийдвэрлэхийн тулд бодлогын зээлийн хэлбэрээр санхүүгийн туслалцаа авах хүсэлтийг Монгол Улсын Засгийн газар АХБ-нд тавьсан. Агаарын бохирдол нь (i) иргэдийн, үүний дотор хүүхэд, ядуу иргэдийн эрүүл мэндэд их хэмжээний хохирол учруулж; мөн (ii) хэдийн сул байгаа эдийн засагт урт хугацааны нэмэлт дарамт үүсгэж, эрүүл мэнд ба эдийн засгийн

зардлыг нэмэгдүүлж байна. Санал болгож буй зээлийн хөтөлбөр нь Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр 2017-2025-т суурилсан болно.

Төслийн үндэслэл ба Улс/Бүс нутгийн стратегитэй уялдсан байдал

Улаанбаатар хот дэлхийн хамгийн хүйтэн нийслэлд тооцогддог, өвлийн улиралд буюу 10-аас 3 дугаар саруудын хооронд агаарын температур тогтмол 20-иос доош хэм рүү ордог. Мөн сүүлийн жилүүдэд дэлхий дээрх агаарын бохирдол хамгийн өндөртэй хотуудын нэг болсон. 2018 оны 1 дүгээр сарын турш, орчны агаар дахь хорт тоосонцрын агууламж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хүлээн зөвшөөрсөн хэмжээнээс бараг 40 дахин их байсан. Агаарын бохирдлын түвшин аюултай хэмжээнд хүрдэг нь Улаанбаатар хотын оршин суугчдын хувьд өвөл бүр тулгардаг хэвийн үзэгдэл болсон бөгөөд иргэдийн эрүүл мэндэд ноцтой хор уршиг учруулж байна. Эрүүл мэндийн зардал, алдагдсан бүтээмж, ужиг архаг өвчин, богино наслалт зэрэг нь Улаанбаатар хотын иргэдийн, нэн ялангуяа хоол тэжээл, эрүүл мэндийн үйлчилгээг зохих хэмжээнд авч чаддаггүй ядуу иргэдийн эдийн засгийн байдал, амьдралын чанарт хүндээр тусдаг.

Хүүхдүүд агаарын бохирдолд нэн өртөмтгий байдаг. Улаанбаатар хотын хот төлөвлөлт, хот байгуулалт муу байгаа нь агаарын бохирдлын үндсэн шалтгаан болдог. Сүүлийн 20 жилийн турш Улаанбаатарт хотжилт хурдацтай явагдсан, илүү сайхан амьдралыг эрэлхийлсэн, эсвэл уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн байгалийн гамшигт нэрвэгдэж хөдөө орон нутагт амьжиргаагүй болсон иргэд нийслэл хот руу олноор шилжин ирж суурьшсантай холбоотой. Шинээр суурьшсан иргэдийг багтаахын тулд хотын төв хэсэг багахан хэмжээнд, харин хотын захын гэр хорооллууд асар ихээр тэлсэн, гэр хороолол нь ус, ус татуурга, ариун цэврийн байгууламж, халаалт, нийтийн тээврийн зохих хангамж хангалтгүй.

Гэр хороололд дийлэнх айл өрх амьдарч буй байшин сууцаа халаах, хоол унд бэлтгэхийн тулд түүхий нүүрс (нэн ядуу өрхүүд хатуу хог хаягдал) түлдэг. Улсын ба хувийн эзэмшлийн барилгууд хорт бодис ялгаруулалт ихтэй, үр ашиг багатай, нүүрсээр ажилладаг нам даралтын зуухнууд ашигладаг. Бохирдуулалт ихтэй эдгээр эрчим хүчний үүсгүүр нь агаарын бохирдлын хамгийн том эх үүсвэр болж хотыг тэр чигээр нь бохирдуулдаг бөгөөд орчны агаар дахь 2.5 микрометр тоосонцрын агууламжийн 80 хүртэл хувийг бүрдүүлдэг гэсэн тооцоо байна. Дийлэнх ажлын байр, үйлчилгээ төвлөрсөн Улаанбаатар хотын төв хэсэгт хувийн тээврийн хэрэгсэл, хортой бодис ялгаруулалт ихтэй нийтийн тээврийн автобуснуудын тоо улам нэмэгдсээр байна. Энэ нь орчны агаар дахь 2.5 микрометр тоосонцрын агууламжийн 10 орчим хувийг бүрдүүлдэг аж. Нүүрсээр ажилладаг цахилгаан, дулааны станцууд орчны агаар дахь 2.5 микрометр тоосонцрын агууламжийн 5-6 хувийг бүрдүүлдэг, харин хучилтгүй шороон замын тоос, цахилгаан станцын үнс 4-5 хувийг эзэлдэг гэжээ. Хотын газар зүйн байрлал, уур амьсгал нь агаарын бохирдолд мөн нөлөөлдөг. Улаанбаатар хот нь уулаар хүрээлэгдсэн, мөн өвөл, намрын улиралд хүйтэн, хуурай цаг ууртай тул агаарын урсгал хот орчимд түгжигдэж, агаарын бохирдол салхинд туугдах боломжгүй байдаг.

Хот байгуулалт, эрчим хүчний төлөвлөлт буруу, дэд бүтцийн хөрөнгө оруулалт хангалтгүй байх нь хотын хөгжилд сөргөөр нөлөөлж агаарын бохирдлыг нэмэгдүүлж, улмаар тухайн хотод амьдрах боломжгүй болгодог. Улаанбаатар хотод эдгээр хүчин зүйлсийн хажуугаар эдийн засгийн өсөлт саарч, төсвийн байдал муудаж байгаа тул уг ээдрээтэй асуудлыг шийдвэрлэх нөөц боломж Засгийн газарт хомс байна.

2014 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт татарч, ашигт малтмалын үнэ буурсан, Монголын худалдааны хамгийн том түнш болох БНХАУ-ын өсөлт саарсан зэргээс үүдэн ДНБ-ийн өсөлт 2011 онд 17.3 хувь байсан бол 2016 онд 1.2 хувь болтол унасан. Эдгээрээс үүдэн Монгол Улс төсвийн хямралд орсон бөгөөд одоогийн байдлаар эдийн засгийн бага зэргийн сэргэлт ажиглагдаж байна. Олон улсын валютын сангаас тусгай хөтөлбөр хэрэгжүүлж өрийн тогтвортой байдлыг сэргээх, төсөв санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилго тавьсан нь эдийн засагт эерэг нөлөө үзүүлж, өсөлт 2017 онд 5.1 хувь болжээ. Байгаль орчны тогтвортой байдлыг бэхжүүлэх нь АХБ-ны Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх 2017-2020 оны Түншлэлийн стратегийн нэг чухал тулгуур юм. АХБ нь Улаанбаатар хотын агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг бууруулах талаар үндэсний хөтөлбөрийн хүрээнд гаргаж буй хүчин чармайлтыг дэмжинэ, үүнд зардлын үр ашигтай бодлогын арга хэмжээнд суурилсан үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход нь туслалцаа үзүүлэх юм.

Холбогдох агентлагуудын чадавхийг бэхжүүлэх ба тэдгээрийн уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулах үүднээс уг хөтөлбөр нь (i) хөтөлбөрт тусгасан зарим арга хэмжээнүүдийг дэмжинэ, (ii) санхүүгийн болон эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой, тогтвортой арга хэмжээгээр дамжуулан бодлогын зорилтуудыг уялдуулахыг дэмжинэ, мөн (iii) зөрчилдсөн арга хэмжээ, үйлдлийг аль болох багасгахад анхаарна. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд зориулан хангалттай нөөц хөрөнгийг цаг хугацаанд нь хуваарилуулах асуудалд энэхүү хөтөлбөр мөн анхаарч баталгаажуулна. Үүний тулд уг хөтөлбөр нь агаарын бохирдлын хэмжээг бууруулахад чиглэсэн улсын хөрөнгө, нөөцийг эрэмбэлэх, өсгөн үржүүлэх, зардлын үр ашиг бүхий арга хэмжээнд төвлөрүүлэх, хувийн хэвшлийн санхүүжилт татахад өдөөгч болох зэрэг алхмууд хийнэ.

Төслийн үр нөлөө	Улаанбаатар хотын амьдралын чанар, нийтийн эрүүл мэнд сайжирсан байна
Төслөөс хүлээгдэж буй үр дүн	
Төслийн үр дүн	Улаанбаатар хотын агаарын чанар сайжирсан байна
Үр дүнд чиглэсэн ахиц дэвшил	
Хэрэгжилтийн явц	
Төслийн гүйцэтгэлүүд ба үйл ажиллагаа	Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт сайжирсан байна, агаарын бохирдлын хяналт, зохицуулалтын орчин боловсронгуй болсон байна Агаарын бохирдлыг бууруулж, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ

Байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хот төлөвлөлт, эрчим хүч, тээврийн нэгдсэн тогтолцоог хангах механизм

Төслийн хэрэгжилтийн байдал
(үр дүн, үйл ажиллагаа ба тулгарч буй асуудлууд)

Газарзүйн байршил

Улаанбаатар хот

Хамгааллын ангиллууд

Байгаль орчин

C

Албадан нүүлгэн шилжүүлэлт

C

Уугуул иргэд

C

Байгаль орчин болон нийгмийн асуудлуудын хураангуй

Байгаль орчин

Байгаль орчны сөрөг нөлөө байхгүй гэж тодорхойлсон, тиймээс байгаль орчны хувьд хөтөлбөрийг C ангилалд хамруулсан.

Бодлогын зээл нь агаарын бохирдлыг богино, дунд, урт хугацаанд бууруулахын тулд олон талт, системтэй цогц арга барилыг ашиглана. 80,000 тонн сайжруулсан түлш нийлүүлэх нь богино хугацааны нэг гол бодлого бөгөөд агаарын бохирдлыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Урт хугацаанд, гэр хорооллын дахин төлөвлөлт хийснээр дээрх арга хэмжээний хэрэгцээ шаардлага буурна. АХБ-ны техник туслалцааны төсөл нь үр ашигтай, ил тод, хариуцлагатай арга замаар өндөр чанартай, ялгарал багатай нүүрс түгээх үр дүнтэй загварыг бий болгоход тусална. Ингэснээр агаарын бохирдлыг буруулж сайжруулсан түлшний эрэлт, нийлүүлэлтийг дэмжиж, улмаар бодлогын тогтвортой байдлыг бүрдүүлнэ. Үүнээс гадна, халаалтын сүлжээг өргөжүүлж гэр хорооллын айл өрх, байгууламжуудыг төвлөрсөн халаалтад холбож, нам даралтын зуухнуудыг буулгаснаар агаар бохирдуулагч гол бодисууд болон хүлэмжийн хийн ялгарлыг цааш бууруулна. Хар нүүрстөрөгч буюу насжилт богинотой бохирдуулагч бодисын ялгарлыг бууруулах замаар уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэж буй сөрөг үр дагаврыг давхар бууруулах нь байгаль орчинд үзүүлэх бас нэг эерэг үр нөлөө болно.

Агаарын чанарын хяналтын системийг сайжруулах зэрэг бусад бодлогын арга хэмжээ нь зохицуулалт, байгаль орчны хяналт шалгалтыг сайжруулах замаар ялгарлыг бууруулахад нөлөөлөх хэдий ч бодит хувь нэмрийг тоон үзүүлэлтээр илэрхийлэхэд хүндрэлтэй юм. Гэхдээ хөтөлбөрийн уур амьсгалын санхүүжилтийг тооцохын тулд төслийн баг хувь тэнцүү арга барилыг авч ашигласан бөгөөд, 1-р үе шатны хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаврыг бууруулахад чиглэсэн бодлогын 2 арга хэмжээ, 2-р үе шатны хүрээнд бодлогын 4 арга хэмжээ авахаар төлөвлөсөн.

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой шууд ба шууд бус эрсдэлүүдийг бууруулахын тулд хот байгуулалт ба эрчим хүчний төлөвлөлтийн агентлагууд уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөө хөдөө орон нутгийн ирээдүйн хэв шинжид хэрхэн

нөлөөлөх (жишээлбэл, уур амьсгалын өөрчлөлтөөс улбаалан гамшгийн давтамж хэр нэмэгдэх гэх мэт) ба хотын орчинд дэд бүтцэд ямар нөлөө үзүүлэх (жишээлбэл, халууны давалгаа цахилгааны огцом эрэлт бий болгох, эсвэл хэт хүйтэн температур сэргээгдэх эрчим хүчний нийлүүлэлтийн системд саад учруулах) зэрэг асуудлыг харгалзан үзэж байх бодлогын үүрэг даалгавар авна.

Албадан нүүлгэн шилжүүлэлт

Хөтөлбөрийн үйл ажиллагаа бодлогын шинэчлэлд чиглэнэ, эдгээрийн ач тусыг Улаанбаатар хотын бүх иргэд хүртэнэ. Бодлогын арга хэмжээнүүд албадан нүүлгэн шилжүүлэлтэд хүргэхгүй, уугуул иргэдэд сөрөг нөлөө үзүүлэхгүй. Албадан нүүлгэн шилжүүлэх тухайд хөтөлбөрийг С ангилалд хамааруулсан.

Уугуул иргэд

Уугуул иргэдийн тухайд хөтөлбөрийг С ангилалд хамааруулсан.

Оролцогч талуудын харилцаа, оролцоо ба хэлэлцүүлэг

Төслийн төлөвлөлтийн үед

Төслийн хэрэгжилтийн үед

Хариуцагч талууд

АХБ-ны хариуцсан ажилтан

Мариа Пиан Анкора

АХБ-ны хариуцсан газар

Зүүн Азийн газар

АХБ-ны хариуцсан хэлтэс

Байгаль орчин, байгалийн баялаг ба хөдөө аж ахуйн хэлтэс, Зүүн Азийн газар

Хэрэгжүүлэгч байгууллага

*Сангийн яам
ANUDARI@MOF.PMIS.GOV.MN
Засгийн газрын 2 дугаар байр
Нэгдсэн үндэстний гудамж-5/1
Улаанбаатар -210646, Монгол Улс*

Цагалбар

Төслийн үзэл баримтлалыг батлах

2017 оны 9 дүгээр сарын 21

Баримт цуглуулах, судалгаа хийх

2017 оны 10 дугаар сарын 23-31

Удирдлагын хянан хэлэлцэх хурал

2018 оны 1 дүгээр сарын 23

Төслийг батлах

2018 оны 3 дугаар сарын 23

Сүүлд хийгдсэн төслийн хяналт

-

Төслийн мэдээллийн тайланг сүүлд шинэчилсэн огноо

2018 оны 3 дугаар сарын 23

Зээл 3648-МОН

Чухал огноо

Төсөл дуусах огноо

Төсөл батлагдсан огноо	Гэрээнд гарын үсэг зурсан огноо	Хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн огноо	Анхны хувилбар	Шинэчилсэн	Бодит
2018 оны 3 сарын 23			2019 оны 5 сарын 30	-	-

Санхүүжилтийн төлөвлөгөө / Ашиглалт		Зээлийн зарцуулалт			
	Нийт (сая ам.доллар)	Огноо	АХБ	Бусад	Хувь
Төслийн зардал	130.00	Гэрээлэлт, өссөн дүгээр			
АХБ	130.00	2018-03-23	0.00	0.00	0%
Засгийн газар	0.00	Зарцуулалт, өссөн дүнгээр			
Хамтарсан санхүүжилт	0.00	2018-03-23	0.00	0.00	0%

Төслийн веб хуудас	https://www.adb.org/projects/51199-001/main
Мэдээлэл авахыг хүсвэл	http://www.adb.org/forms/request-information-form?subject=51199-001
Төслийн мэдээллийн тайланг үүсгэсэн огноо	2018 оны 5 дугаар сарын 11

Төслийн мэдээллийн тайлан (ТМТ)-д төсөл, хөтөлбөрийн талаарх хураангуй мэдээлэл агуулагддаг бөгөөд энэхүү тайлан нь тогтмол шинэчлэгддэг тул зарим нэг мэдээлэл тайлангийн эхний хувилбарт багтаагүй ч дараачийн хувилбарт орж болно. Төлөвлөж буй (батлагдаагүй) төслийн талаарх мэдээлэл нь урьдчилсан бөгөөд тойм шинж чанартай.

АХБ нь энэхүү ТМТ-г хэрэглэгчдэд гагцхүү мэдээллийн чанартай хүргэж байгаа бөгөөд ямарваа баталгааг олгохгүй. АХБ-ны зүгээс агуулгын чанарт ихээхэн анхаардаг хэдий ч энэхүү тайланд агуулагдсан мэдээллийг “байгаагаар нь” буюу арилжааны шаардлагыг хангах, тодорхой зорилгоор ашиглахад нийцэх эсвэл бусдын эрхэнд халдахгүй байх гэх мэт ямарваа нэгэн шууд болон шууд бус баталгааг өгөхгүйгээр толилуулж байна. АХБ нь тайлан дахь мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлын талаарх ямар нэгэн баталгаа, эсхүл мэдэгдэл хийгээгүй болно.